

“ҮНДЭСНИЙ ГЕОМЭДЭЭЛЛИЙН САН” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.4 дэхь заалтад “Геомэдээллийн нэгдсэн сан бий болгож, ашигт малтмал, хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох”, “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.2.2.9 дэхь заалтад “Геологи, эрдэс баялгийн судалгааны ажлын тайлан, үр дүнг олон улсын жишиг, стандартад нийцсэн аргачлал, нөөцийн ангиллын дагуу нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн нэгдсэн санг иж бүрнээр бүрдүүлэн баяжуулах”, 3.2.2.10 дахь заалтад “Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг цахим мэдээллийн технологийн системд шилжүүлж, геологи, хайгуулын ажлын тайлан, анхдагч баримт материал болон дээж, чулуулгийн сорьц хадгалах, архивлах шинэчилсэн заавар, стандартыг бий болгох”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.60 дахь заалтад “Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна” гэж тус тус заасан зорилтууд болон “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-өөс ирүүлсэн “Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөрийг боловсруулан батлуулах” гэсэн чиглэл нь “Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг боловсруулах үндэслэл болж байна.

Эрдэс баялгийн салбарын хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйлийн нэг нь геологийн мэдээлэл байдаг бөгөөд тэр дундаа тогтмол нэмэлт мэдээллээр баяжигдаж байгаа геологийн зураг, өсөн нэмэгдэж буй ашигт малтмалын нөөц, хүдэржилт, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа зэргээс гадна хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгаль орчны тэнцвэрт байдлын мэдээллийг нэгдсэн бодлогоор олон нийтэд хүртээмжтэй түгээх, мэдээллэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг үнэн бодит, найдвартай мэдээллээр хангах, үйл ажиллагааны эрсдэлийг нь бууруулах, оновчтой арга аргачлал сонгоход нь дэмжлэг болох, олон нийтэд тухайн салбарыг сурталчилан таниулах, нэгдсэн нэг ойлголттой болгох, шинэ орд илрэлийн геологийн тогтоц, холбогдох бусад мэдээллийг харьцуулах боломжоор хангах, тухайн бүсийн хэтийн төлөв, геологийн тогтоцыг бүрэн хэмжээгээр судлахад дэмжлэг болох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хэрэгцээт мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх, цаашлаад эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу хөгжүүлэх явдал юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох, иж бүрнээр бүрдүүлэн баяжуулах, мэдээллийг боловсруулах, нууцад хамааруулснаас бусад мэдээллийг түгээх, үйлчилгээг хялбаршуулах, анхдагч баримт материал болон дээжийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хүний нөөцийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үндэсний геомэдээллийн санг олон улсын түвшинд хүргэх, гео-орчны талаарх мэдээллийг цогцолбороор нь бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

Зорилт 1. Геомэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Зорилт 2. Олон улсын жишигт нийцсэн үндэсний геомэдээллийн иж бүрэн санг бий болгоно.

Зорилт 4. Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа тайлан, холбогдох материалыг цэгцлэх, цахим хэлбэрт хөрвүүлэх, хэрэглэгчдийг орчин үеийн уншлагын танхимаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Зорилт 3. Үндэсний геомэдээллийн сангийн үйл ажиллагааны аюулгүй байдлын тогтолцоог бий болгоно.

Зорилт 5. Амьдралын гео-орчны талаарх мэдээллийг цогцолбороор нь бүрдүүлэх зарчмыг боловруулж, энэ талаарх мэдээллийг бүрдүүлэх эх суурийг тавина.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2018-2023 онд хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилт нь дараах үе шаттай байна.

2.3.1. Нэгдүгээр үе шат (2018-2019 он). Энэ үе шатанд Үндэсний геомэдээллийн сангийн загварыг боловсруулах, тус санг байгуулах эрхзүйн орчныг боловсронгуй болгох, үйл ажиллагаанд мөрдөх заавар, загварыг бий болгох, Геологийн төв архивт хадгалагдаж байгаа геологийн үндсэн мэдээллүүдийг цахим хэлбэрт шилжүүлэх, уншлагын танхимыг цахим үйлчилгээтэй болгох, олон нийтэд нээлттэй, цахим орчимд мэдээллээр үйлчлэх боломжийг бүрдүүлэх.

2.3.2. Хоёрдугаар үе шат (2020-2022 он): Улсын эдийн засгийн шаардлага, хөгжлийн төлөв байдалд нийцүүлэн мэдээллийг багцлан боловсруулах, шинжилгээ хийх, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зөвлөмж гаргах, нэгдсэн мэдээллээр төрийн байгууллагуудыг хангах, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх, аж ахуйн нэгжүүдийн хайгуулын ажлын эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, мэдээллийг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг нэмэгдүүлэх, ил тод байдлын тогтолцоог боловсронгуй болгох, цахим геомэдээллийн санг амьдарлын гео-орчинтой холбоотой төрөл бүрийн мэдээллээр арвижуулан баяжуулах нөхцлийг бий болгох.

2.3.3. Гуравдугаар үе шат (2023 он): Хөтөлбөрийн эхний хоёр шат хэрэгжсэнээр бий болсон үр дүнд дүн шинжилгээ хийх, тавьсан зорилго, зорилтуудын хэрэгжилтийн түвшинг тодорхойлох, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтуудыг боловсруулах.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Геомэдээллийн сангийн асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг холбогдох бусад эрх зүйн баримт бичигтэй уялдуулах, сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.2. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс ирүүлж буй хайгуулын ажлын тайлан, түүний тоон өгөгдөл ба мэдээллийг үндэсний геомэдээллийн санд хүлээж авах загвар, холбогдох үйл ажиллагааны зааврыг боловсруулж батлуулах;

3.1.3 Нээлттэй ба хязгаарлагдмал, төлбөртэй болон төлбөргүй өгөгдөл, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх, түгээх зааврыг нарийвчлан боловсруулж батлуулах;

3.1.4 Геологийн мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг мөрдлөгө болгох.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. Олон улсын түвшинд нийцэхүйц Үндэсний геомэдээллийн сангийн загварыг боловсруулж, ашиглалтад оруулах;

3.2.2. Геологийн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, нэгдсэн загварт хөрвүүлэх гарын авлагыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах;

3.2.3. Монгол Улсын хэмжээнд геологи, тектоник, геохимийн болон бусад зургуудыг нэгтгэх;

3.2.4. Геомэдээллийг цахим орчинд суурилсан газарзүйн мэдээллийн систем бүхий каталог-метадата системээр хөгжүүлэх, холбогдох мэдээллээр баяжуулах ба үйлчилгээнд нэвтрүүлэх;

3.2.5. Үндэсний геомэдээллийн санг тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс ирүүлэх өгөгдөл, төлөвлөгөө, тайланг тоон хэлбэрээр хүлээн авч тогтмол баяжуулах;

3.2.6. Төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох, хэрэглэгчид мэдээллийг цогц байдлаар авах боломжийг хангах мэдээллийн системүүдийн үйлчилгээний холбоосыг хөгжүүлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх;

3.2.7. Геомэдээллийн захиалгат үйлчилгээг бий болгон нэвтрүүлэх.

3.3. Хөтөлбөрийн 3 дүгээр зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. Геологийн ажлын тайлангуудыг (үндсэн ба хавсралтууд) тоон хэлбэрт шилжүүлэх, нэгдсэн загварын дагуу хайх, олох, унших, хэвлэх гэх мэт үйлдэл бүхий системчилсэн сан үүсгэж үндэсний геомэдээллийн нэгдсэн сантай холбох;

3.3.3. Уншлагын танхимыг олон улсын жишигт нийцсэн үйлчилгээтэй болгох, үйлчилгээний төлбөрийг цахим хэлбэрт оруулах;

3.3.4. Геологийн баримтын төв архивын анхдагч материал (тайлан, чулуун дээж) хадгалах байрыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, шат дараалсан арга хэмжээ авах, боловсронгуй болгож, сайжруулах;

3.3.5. Геологийн баримтын төвд хадгалагдаж байгаа чулуун анхдагч материалуудыг бүртгэлжүүлэх, /орд илрэл, дээжийн нэр, дугаар, дээж авсан газрын нэр, нас, координат, номенклатур зэргээр сонголт хийх боломжтой болон бусад хэлбэрээр/ баяжуулах;

3.4. Хөтөлбөрийн 4 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. Геомэдээллийн сангийн үйл ажиллагаанд олон улсын түвшний программ хангамжийг нэвтрүүлэх, техник хангамжийн шинэчлэл хийх;

3.4.2. Техник хангамжийн аюулгүй ажиллагаа, вирус, гадны халдлагаас хамгаалах хамгаалалтын системийг иж бүрнээр нэвтрүүлэх;

3.4.3. Боловсон хүчнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудад дадлагажуулах, сургалт зохион байгуулах;

3.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. Амьдрах орчны геологийн хүчин зүйлийн нөлөөлөл, гүйцэтгэх үүрэг зэрэгт үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх үүднээс гео-орчны талаарх мэдээллийг цогц байдлаар нь бүрдүүлэх арга аргачлал, зарчмыг боловсруулах;

3.5.2. Гео-орчны байдалд үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг тусгайлан боловсруулсан аргачлалын дагуу цогц байдлаар бүрдүүлж Үндэсний геомэдээллийн сангийн салшгүй нэг хэсэг болгон нэгтгэх ажлыг эхлүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн үр нөлөө

4.1.1. Геомэдээллийн сангийн харилцааг зохицуулж байгаа хууль эрхзүйн орчин боловсронгуй болж, нууцад хамаарахаас бусад материалыг нээлттэй ашиглах боломж бүрдсэн байна.

4.1.2. Олон улсын жишиг, сайн туршлагад нийцсэн бүтэц, аюулгүй байдлыг хангасан, хурдан шуурхай, байгууллага хооронд мэдээлэл солилцох боломж бүхий Үндэсний геомэдээллийн сан *burdene*.

4.1.3. Улсын эдийн засгийн шаардлага, хөгжлийн төлөв байдалд нийцүүлэн шаардлага хангахуйц мэдээлэл боловсруулан, дүн шинжилгээ хийх замаар төрийн байгууллагуудыг шийдвэр гаргахад мэргэжлийн мэдээлэл, зөвлөмжөөр хангах, дэмжлэг

үзүүлэх болон геологийн судалгааны ажлын эрсдэлийг бууруулах чиглэлээр геомэдээллийн чанарын түвшинг сайжруулсан байна.

4.1.4. Геомэдээллийн сангуудын орон зайн мэдээллүүдийг нэгдсэн хэв загварт хөрвүүлэх ажил бүрэн хийгдэж Монгол Улсын хэмжээнд геологийн ба бусад зургийг нэгтгэсэн байна.

4.1.5. Геологийн баримтын төв архивт хадгалагдаж буй тайлангуудыг тоон хэлбэрт шилжүүлэн, уншлагын танхимыг орчин үеийн цахим үйлчилгээтэй болгож, бичмэл тайлангийн хадгалалт, хамгаалалт, чулуун дээжний сан дахь дээжнүүдийн бүртгэл, хадгалалтыг олон улсын жишигт хүргэсэн байна.

4.2. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.2.1. Хууль тогтоомжийн шинэчлэл;

4.2.2. Олон улсын түвшинд нийцсэн геомэдээллийн сангийн бүтэц;

4.2.3. Хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ;

4.2.4. Хөрөнгө оруулагчдын өсөлт;

4.2.5. Бусад.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт;

5.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны буцалтгүй тусламж.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага удирдан зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хяналт, шинжилгээ хийж хөтөлбөр хэрэгжих үе шат тус бүрт үнэлгээ хийнэ.